

**ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
ШИНЖИЛГЭЭ 2016 ОН  
/ТОВЧОО/**

**УЛААНБААТАР  
2017 ОН**

## ШУТИС-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

### ОРШИЛ

ШУТИС-ийн хувьд 2016 он “ШУТИС-2021” мастер төлөвлөгөөний гарааны жил байсан бөгөөд багш, ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний ажлын чанарыг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, хүний нөөцийн болон санхүүгийн чадавхийг сайжруулах зэрэгт гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

ШУТИС-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн шинжилгээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүний 9 сургууль, 2 институт, ШУТАС, КТДС, Захиргаа, Эрдэм шинжилгээний алба, хүрээлэн, Хэвлэлийн газар, Эрдэмнэт сүлжээний төв зэрэг нийт 21 нэгж, оюутны байрны санхүүгийн үйл ажиллагааг нэгтгэхээр болсон. ШУТИС-ийн СЭЗА-аас УСНББОУС-ын санхүүгийн тайлагналын үзүүлэлт, Сангийн сайдын №343 тоот “Аж ахуй нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”, “ШУТИС-2021 он” мастер төлөвлөгөөний үзүүлэлтүүдэд тулгуурлан санхүүгийн шинжилгээ хийх удирдамжийг боловсруулсан.

Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн санхүүгийн тайланг Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А), үр дүнгийн тайлан (СТ-2А), мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А), цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А), санхүүгийн тайлангийн тодруулга (ТБСТТ-1-12)-аар тус тус гаргаж, ШУТИС-ийн удирдлагын нэгдсэн системийн дэд хэсэг болох улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн санхүүгийн мэдээллийг боловсруулах “*I-Finance*” санхүүгийн программаар санхүүгийн тайланг гарган, Plastic программаар санхүүгийн тайлан нэгтгэдэг.

Үндэсний аудит, СМД Аудит ХХК-ийн сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүгнэлт, акт, зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа дүгнэлт хийж ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 1788 орон тоотойгоос үндсэн орон тооны профессор, багш 1037, ахлах болон дээд сургууль, МСҮТ-ийн багш 52 нийтдээ 1089 багшлах боловсон хүчинтэйгээр ажилласан байна. Нийт оюутны тоо: Бакалавр (хавар, намрын улиралд идэвхтэй сурч буй сонголт хийсэн оюутан) 17266, магистр-1923, доктор-339, МСҮТ, ахлах сургуулийн суралцагч 1051 байна.

Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, нэгжүүд тус бүрийн 2016 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд хийсэн шинжилгээ, үйл ажиллагааны үр дүнг захирлын зөвлөлийн, захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцсэн. Ректоратын 2017 оны 03 дугаар сарын 21-ний хурлаар урьдчилсан байдлаар танилцуулаад хурлаас гарсан санал дүгнэлт, зөвлөмжийг тусган Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

ШУТИС-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн шинжилгээг дараах чиглэлүүдээр хийж, ерөнхий дүгнэлт, цаашид анхаарах асуудлаар тодорхой зорилтыг гаргалаа. Үүнд:

1. Балансын бүтцийн шинжилгээ
2. Орлогын шинжилгээ
3. Зардлын шинжилгээ
4. Нэг оюутанд ноогдож буй зардлын шинжилгээ
5. Оюутны байрны орлого, зардлын шинжилгээ
6. Төвлөрсөн арга хэмжээний орлого, зардал
7. Санхүүгийн харьцааны шинжилгээ
8. Дүгнэлт, цаашид тавих зорилт

## **НЭГ. БАЛАНСЫН БҮТЦИЙН ШИНЖИЛГЭЭ**

Балансын бүтцийг авч үзвэл нийт хөрөнгө 86,675.1 сая төгрөгт хүрч урьд оны мөн үетэй харьцуулахад 4% буюу 3.3 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Эргэлтийн хөрөнгө 47.8 хувийг, эргэлтийн бус хөрөнгө 52.2 хувийг эзэлж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эргэлтийн хөрөнгө 3.1 пунктээр нэмэгдсэн байна. Эх үүсвэрийн хувьд өр төлбөр 9.3 хувь, эзний өмч 90.7 хувийг тус тус эзэлж өр төлбөрийн дүн өнгөрсөн оноос 0.3 пунктээр буурчээ.


### **БАЛАНСЫН БҮТЭЦ (сая төгрөгөөр)**

д/д	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2015 он		2016 он		Өөрчлөлт	
		дүн	Дүнд эзлэх хувь	дүн	Дүнд эзлэх хувь	Абсолют	Харьцангуй
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	27,019.59	32.4%	30,244.00	34.9%	3,224.41	11.9%
2	Авлага	7,899.40	9.5%	8,555.80	9.9%	656.40	8.3%
3	Бараа материал	2,356.39	2.8%	2,644.40	3.1%	288.01	12.2%
	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,275.39</b>	<b>44.7%</b>	<b>41,444.20</b>	<b>47.8%</b>	<b>4,168.81</b>	<b>11.2%</b>
1	Бусад хөрөнгө	523.97	0.6%	362.70	0.4%	-161.27	-30.8%
2	Үндсэн хөрөнгө	45,547.01	54.6%	44,868.20	51.8%	-678.81	-1.5%
	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>46,070.98</b>	<b>55.3%</b>	<b>45,230.90</b>	<b>52.2%</b>	<b>-840.08</b>	<b>-1.8%</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>83,346.37</b>	<b>100.0%</b>	<b>86,675.10</b>	<b>100.0%</b>	<b>3,328.73</b>	<b>4.0%</b>

### **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ШИНЖИЛГЭЭ**

Эргэлтийн хөрөнгө мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материалаас бүрдэж байна. Эргэлтийн хөрөнгө нийт дүнгээрээ 4.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 41.4 тэрбум төгрөгт хүрчээ. Эргэлтийн хөрөнгийг бүтцийг урьд оны мөн үетэй харьцуулан авч үзвэл; мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 11.9% буюу 3.2 тэрбум төгрөгөөр, авлага 8.3% буюу 656.4 сая төгрөгөөр, бараа материал 12.2% буюу 288.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 30.2 тэрбум төгрөг, үүнээс 7.6 тэрбум төгрөг нь сургалтын төлбөр, оюутны байр, гэрээт ажил, төслийн урьдчилж орсон орлого байна. (Урьдчилж орсон орлого нь өнгөрсөн оны мөн үеэс 774.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.) Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 30.2 тэрбум төгрөгөөс урьдчилж орсон орлогыг хасаж тооцсоноор тайлант оны цэвэр шилжих үлдэгдэл нь 21.96 тэрбум төгрөг болжээ. Цэвэр шилжих үлдэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.6 тэрбум төгрөг буюу 13.4%-иар нэмэгдсэн нь тайлант онд Засгийн газрын 38 тоот тогтоолоор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаа хийгээгүй, сургалтын тоног төхөөхөрөмж худалдан авах ажлуудыг хойшлуулсантай холбогдож үлдэгдэл нэмэгдсэн дүнтэй байна.



Балансын бүтцээс харахад эргэлтийн бус хөрөнгө тайлант онд 1.8%-иар буурсан нь Төрийн өмчийн хорооны 2016 оны 12 сарын 27-ний өдрийн 320 тогтоол тогтоолоор 3.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасах тогтоолын дагуу үндсэн хөрөнгийг данснаас хассантай холбогдож буурсан.

### АВЛАГА

Авлага урьд оны мөн үетэй харьцуулахад 8.3 хувь буюу 656.4 сая төгрөгөөр өсжээ. Тайлант онд байгууллагатай холбоотой сургалтын төрийн сангаар суралцагч оюутны сургалтын төлбөрийн санхүүжилт дутуу хийгдсэнээс 499.0 сая төгрөгийн гэрэл цахилгаан уур ус, түлш халаалтын зардалд 804.6 сая төгрөгийн авлага шинээр үүссэн байна. МСҮТөвийн суралцагчийн хувьсах зардалд 109.9 сая төгрөгийн, хувь хүмүүстэй холбоотой хувиараа төлбөрөө төлдөг оюутны сургалтын төлбөрт 905.1 сая төгрөгийн авлага шинээр тус тус нэмэгджээ. Тайлант оны жилийн эцсийн байдлаарх авлагыг төрлөөр харуулбал:

- Сургалтын төлбөрийн авлага -3,988.1 сая төгрөг үүний 756.0 сая төгрөг нь Сургалтын төрийн сангаас авах авлага байна.
- Тогтмол зардлын санхүүжилтийн авлага 1,204.9 сая төгрөг (БСШУСЯам)
- Барилга байгууламжтай холбоотой авлага -1,857.5 сая төгрөг
- Дараа тайлангийн 321.0 сая төгрөг
- Бусад 1,184.3 сая төгрөгийн авлага тус тус багтаж байна.

Дараах хүснэгтэнд бүрэлдэхүүн сургууль тус бүрийн тайлант жилийн эцсийн авлагыг харуулав.

**БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИУДЫН АВЛАГА (сая төгрөгөөр)**

Сургууль	2015 он	2016 он	Үүнээс. Сургалтын төлбөрийн авлага				Өөрчлөлт		Дүнд эзлэх хувь
			Сургалтын төрийн сангаас авах авлага	Хувиараа төлөх	СТС-г суутган тооцооны авлага	Дүнд эзлэх хувь	Тоогоор	Хувиар	
БАС	1335.6	1316.9	66.8	379.0	5.7	34.3	(18.6)	98.6	15.4
БУХС	1210.6	1602.8	87.0	659.7	44.3	49.3	392.2	132.4	18.7
ГУУС	881.0	1251.2	66.0	650.7	0.0	57.3	370.2	142.0	14.6
ДТС	251.2	207.9	41.9	148.2	0.0	91.4	(43.3)	82.8	2.4
МехТС	317.3	397.6	50.7	98.7	11.9	40.6	80.4	125.3	4.6
МХТС	423.3	488.9	65.5	190.6	21.0	56.7	65.6	115.5	5.7
ҮТС	973.5	870.1	57.9	215.3	125.4	45.8	(103.3)	89.4	10.2
ХШУС	382.9	323.2	6.7	53.7	16.9	23.9	(59.8)	84.4	3.8
ЭХС	442.7	426.9	55.6	188.6	22.3	62.4	(15.8)	96.4	5.0
Е-НИ	113.8	32.5	0.0	17.3	0.0	53.2	(81.3)	28.6	0.4
ГХИ	141.1	158.7	1.1	63.2	9.1	46.3	17.6	112.5	1.9
ШУТАС	66.4	287.6	0.0	250.6	0.0	87.1	221.2	433.0	3.4
Косэн	41.9	109.9	0.0	109.9	0.0	100.0	68.0	262.0	1.3
ОМССХ	21.1	32.5				0.0	11.4	154.1	0.4
ОУДБСТ	0.0	206.7	0.0	206.7	0.0	100.0	206.7		2.4
ХГазар	41.2	36.7				0.0	(4.5)	89.1	0.4
ЭША	683.7	475.3				0.0	(208.5)	69.5	5.6
Захиргаа	257.2	204.0				0.0	(53.2)	79.3	2.4
Эрдэмнэт	85.8	94.9				0.0	9.1	110.6	1.1
Төвлөрсөн	205.9	31.4				0.0	(174.6)	15.2	0.4
ӨвТС	23.2						(23.2)	0.0	0.0
<b>ДҮН</b>	<b>7899.5</b>	<b>8555.8</b>	<b>499.2</b>	<b>3232.1</b>	<b>256.8</b>	<b>46.6</b>	<b>656.2</b>	<b>108.3</b>	<b>100.0</b>

Нийт авлагад БУХС, БАС, ГУУС, ҮТС-иудын авлага 10.2-18.7 хувийг эзэлж байна. Сургалтын төлбөрийн авлага 46.6 хувийг эзэлж ДТС, Косэн, ШУТАС, ОУДБСТөвийн авлага 80-с дээш хувьтай байна. Удирдах зөвлөлийн 2017 оны 02 сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолын дагуу сургалтын төлбөрийн 408.1 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаж залруулах бичилт хийгдсэн.

Санхүүгийн хуанлид сургалтын төлбөр төлөлт, гүйцэтгэлийн хувийг 1,4,7,10 саруудад гаргуулан авч нэгтгэж төлбөр төлөлтийн хувь гүйцэтгэл өндөр байгаа бүрэлдэхүүний сургуулиудад сургалтын төлбөрийг барагдуулах талаар ажил зохион байгуулж ажилласан хэдий ч улс орны эдийн засгийн хямрал, ард түмний амьжиргааны түвшин буурч байгаатай холбоотойгоор авлагын хэмжээ өсчээ.

## БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын үлдэгдэл нь оны эхэнд 2,356.4 сая төгрөг байсан бөгөөд тайлант хугацааны туршид 1,628.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,340.9 сая төгрөгөөр хорогдож, жилийн эцэст 2,644.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 12.2 хувиар өссөн байна.

Бараа материалын нэмэгдсэн эх үүсвэрийг авч үзвэл:

- Бараа материалыг худалдан авсан – 1,413.7 сая төгрөг
- Хандиваар 198.3 сая төгрөг
- Шилжүүлэн авсан -16.98 сая төгрөг байна.

Тайлант онд 1,319.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан болон худалдан шилжүүлсэн байна.

Бараа материалын бүтцийн хувьд тусгай зориулалттай материал- 53.7, бусад хангамжийн материал 28.2, бичиг хэргийн материал-12.0, аж ахуйн материал-3.5, үлдсэн 2.3 хувийг засварын материал, түлш шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн /ном/-0.3 хувийг тус тус эзэлж байна. Цаашид бусад хангамжийн материалын хувь хэмжээг бууруулах талаар тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай.


## ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Тайлант онд үндсэн хөрөнгө 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний 2.9 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөр (12.9 хувь нь барилга байгууламжийн, 64.0 хувь нь машин тоног төхөөрөмж, 10.7 хувь нь тавилга эд хогшил, 6.7 хувь ном), 715.4 сая төгрөгийг хандиваар, 372.4 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэжээ. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 27-ны өдрийн 320 тоот тогтоолын дагуу дараах нэр төрлийн 3.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсан. Үүнд:

- Машин тоног төхөөрөмж 2.9 тэрбум төгрөг
- Тавилга, эд хогшил 372.2 сая төгрөг
- Ном, сурах бичиг 38.2 сая төгрөг
- Биет бус хөрөнгө 69.1 сая төгрөг
- Бусад хөрөнгө 2.8 сая төгрөг

Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн хэмжээ 96,582.2 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 654.0 сая төгрөгөөр буурчээ. Нийт үндсэн хөрөнгийн 45.2 тэр бум төгрөг нь цэвэр үндсэн хөрөнгө, 51.4 тэрбум төгрөг нь хуримтлагдсан элэгдэл байна. Үндсэн хөрөнгийн нэмэгдсэн хэмжээг эх үүсвэрээр нь харуулбал:

### Шинээр нэмэгдсэн хөрөнгө, эх үүсвэрээр



Бүрэлдэхүүн сургуулиудын үндсэн хөрөнгийг цэвэр дүнгээр (хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр) харуулав.

### Улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн:

- БСШУСЯамны СДИО хөтөлбөрийн хүрээнд МехТС 69.2 сая төгрөг компьютер, принтер
- Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд МХТС 89.6 сая төгрөгийн компьютер, канон, өнгөт принтер,
- БСШУСЯамнаас ҮТС- 155.0 сая төгрөгийн нано даавуу үйлдвэрлэх төхөөрөмж, ШУТАС-37.0 сая төгрөг, Коосэн ТДС-27.6 сая төгрөгийн физикийн лабораторийн багаж хэрэгсэл, ширээ сандал, ухаалаг самбар, компьютер зэрэг үндсэн хөрөнгийг тус тус бэлтгэжээ.

### Гадаад, дотоодын хандив, бэлэглэлээр бий болгосон хөрөнгө:

МехТС-д БНСУ-ын Чанвоны их сургуулиас 70,0 сая төгрөгийн өртөг бүхий Электрон микроскопын тоног төхөөрөмж, МХТС-д Немон ХХК-с Бичил цех- 55.4 сая төг, ЭХС-д АВВ ХХК-с 2116.3 сая төгрөгийн өртөг бүхий дэд цахилгаан станцын лабораторийн тоног төхөөрөмж, Хойд хятадын Цахилгаан техникийн их сургуулиас 3.0 сая төгрөгийн эрчим хүчний ном, сурах бичиг, Японы Мицубиши корпорациас 14.3 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж, ҮТС-д БНХАУ-ын Шинь Хуа коллежоос 159.2 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын бийр, бичгийн хэрэгсэл, 16.5 сая төгрөгийн өртөг бүхий 15ш компьютер, ГУУС-д Уул уурхайн салбарын мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 45 жилийн ойгоор Эрдэнэт УБУ-ээс 2.1 сая төгрөгийн өртөг бүхий гурвалсан үйлдэлт хэвлэгч төхөөрөмж, Эй Би Би Групп ХХК-с 247.6 сая төгрөгийн Цахилгаан хөтлүүр, автоматжуулалтын тоног төхөөрөмжийг тус тус хандивласан байна.

### ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧИЙН ШИНЖИЛГЭЭ

Нийт өр төлбөр дүнгээрээ 8,101.4 сая төгрөгт хүрч, урьд оны мөн үетэй харьцуулбал 8.3 хувь буюу 623.29 сая төгрөгөөр буурч, эзний өмчийн дүн урьд оноос 3.6 хувь буюу 2,705.44 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 2,582.4 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан бөгөөд урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 68.8 хувь буюу 5,681.79 сая төгрөгөөр буурчээ.

### ӨР ТӨЛБӨРИЙН БҮТЭЦ (сая төгрөгөөр)

д/д	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2015 он		2016 он		Өөрчлөлт	
		дүн	Дүнд эзлэх хувь	Дүн	Дүнд эзлэх хувь	Абсолют	Харьцан гуй
1	Богино хугааат өр төлбөр	7,390.15	8.9%	8,013.80	9.2%	623.65	8.4%
2	Урт хугацаат өр төлбөр	87.96	0.1%	87.60	0.1%	-0.36	-0.4%
	<b>ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>7,478.11</b>	<b>9.0%</b>	<b>8,101.40</b>	<b>9.3%</b>	<b>623.29</b>	<b>8.3%</b>
1	Засгийн газрын сан	23,542.83	28.2%	23,542.80	27.2%	-0.03	0.0%
2	Орон нутгын сан	0.00	0.0%		0.0%	0.00	0.0%
3	Хуримтлагдсан үр дүн	31,246.87	37.5%	33,952.60	39.2%	2,705.73	8.7%
4	Өмнөх үеийн үр дүн	22,982.68	27.6%	31,370.20	36.2%	8,387.52	36.5%
5	Тайлант үеийн үр дүн	8,264.19	9.9%	2,582.40	3.0%	-5,681.79	-68.8%
6	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,078.56	25.3%	21,078.30	24.3%	-0.26	0.0%
	<b>ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>75,868.26</b>	<b>91.0%</b>	<b>78,573.70</b>	<b>90.7%</b>	<b>2,705.44</b>	<b>3.6%</b>
	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>83,346.37</b>	<b>100.0%</b>	<b>86,675.10</b>	<b>100.0%</b>	<b>3,328.73</b>	<b>4.0%</b>

Нийт өр төлбөр, эзний өмч өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.0 хувь буюу 3,328.7 сая төгрөгөөр, нэмэгдэж, 86,675.1 сая төгрөгт хүрчээ. Удирдах зөвлөлийн 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот тогтоолын дагуу 460.8 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг данс бүртгэлд тусгаж залруулга бичилт хийсэн . Доорх схемээр өр төлбөр ба эзний өмчийн бүтцийг харуулж байгаа бөгөөд мөнгөн дүнгийн доод хэсэгт урьд оноос өссөн, буурсан хувийг харууллаа. Нийт өр төлбөр 9.3 хувийг эзний өмч 90.7 %-ийг тус тус эзэлж байна.



**Нийт өр төлбөрт:** Богино хугацаат өр төлбөрийн эзлэх хувь 98.9 хувь болж, урьд оны мөн үетэй харьцуулбал 0.5 пунктээр буурч, урт хугацаат өр төлбөрийн эзлэх хувь өөрчлөлтгүй 1.1 хувийг эзэлж 400.0 мян төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрт сургалтын төлбөрийн болон оюутны байрны урьдчилж орсон орлогын эзлэх хувь 94.0 хувь болж урьд оны мөн үетэй харьцуулбал 2 пунктээр өсч, бусад өглөг 2 пунктээр буурсан үзүүлэлттэй гарчээ. Нийт урьдчилж орсон орлого 7,611.4 сая төгрөг болжээ.



## ХОЁР. ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

Тайлант оны орлогыг үндсэн үйл ажиллагааны, эрдэм шинжилгээний, оюутны байрны, төсвөөс санхүүжигдэх, бусад орлого гэж авч үзлээ. Орлогын дүнг санхүүгийн тайлангийн Санхүүгийн үр дүнгийн /СТ-2А/ тайлангаас авч, тайлант онд үүссэн сургалтын төлбөрийн авлага болон тогтмол зардлын санхүүжилтийн авлагыг хасч, тухайн тайлант хугацааны орлогыг тооцлоо.

### ОРЛОГО (сүүлийн 3 жилийн байдлаар, сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он		Өөрчлөлт		Нийт орлого эзлэх %	2016/2015	Сүүлийн 3 жилийн дундаж
			Төсөв	Гүйцэтгэл	Тоо	Хувь			
Шилжих үлдэгдэл			13,568.6						
I. Үндсэн ҮА-ны орлого	37,072.6	38,742.3	37,524.4	36,567.3	(957.1)	97.4	77.8	94.4	37,460.7
Сургалт төлбөр орлого	34,994.6	36,859.7	35,178.6	34,375.0	(803.6)	97.7	73.1	93.3	35,409.8
Түр сургалтын орлого	2,078.0	1,882.6	2,345.8	2,192.3	(153.5)	93.5	4.7	116.4	2,051.0
II. ЭШ-ний орлого	3,053.7	2,281.1	3,451.0	3,287.1	(163.9)	95.3	7.0	144.1	2,874.0
III. Туслах үйл ажиллагааны орлого	5,882.6	5,620.0	2,108.5	5,507.5	3,399.0	261.2	11.7	98.0	5,670.0
Оюутны байрны орлого	712.0	689.2	881.1	784.1	(97.0)	89.0	1.7	113.8	728.4
Түрээсийн орлого	157.5	136.6	132.0	116.4	(15.6)	88.2	0.2	85.2	136.8
Бусад орлого	5,013.1	4,794.2	1,095.4	4,607.0	3,511.6	420.6	9.8	96.1	4,804.8
IV. Төсвөөс санхүүжих	4,112.2	6,009.8	3,734.1	1,635.7	(2,098.4)	43.8	3.5	27.2	3,919.2
<b>Тайлант үеийн орлого</b>	<b>50,121.1</b>	<b>52,653.2</b>	<b>46,818.0</b>	<b>46,997.6</b>	<b>179.6</b>	<b>100.4</b>	<b>100.0</b>	<b>89.3</b>	<b>49,924.0</b>
<b>Нийт орлого</b>			<b>60,386.6</b>						

Тайлант онд нийт орлого 46,997.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, урьд оны мөн үеийн гүйцэтгэлээс 89.3 хувь буюу 5.7 сая төгрөгөөр буурч, төлөвлөснөөс 0.4 хувь буюу 179.3 сая төгрөгөөр давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад:


- Түр сургалтын орлого- 16.4 хувь буюу 309.7 сая төгрөг
- Эрдэм шинжилгээний орлого – 13.8 хувь буюу 1.0 тэрбум төгрөгөөр
- Оюутны байрны орлого -13.8 хувь буюу 94.9 сая төгрөгөөр өсч,
- Сургалтын төлбөрийн орлого 6.4 хувь буюу 2.3 тэрбум төгрөг
- Түрээсийн орлого 14.8 хувь буюу 20.2 сая төгрөг
- Бусад орлого 4.6 хувь 221.4 сая төгрөг
- Төсвөөс санхүүжих орлого 56.2 хувь буюу 3.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй гарчээ.

Орлогын төсвийг гүйцэтгэлтэй харьцуулахад бусад орлого 4.2 дахин буюу 3.5 тэрбум төгрөгөөр даван биелж сургалтын төлбөрийн, түр сургалт, эрдэм шинжилгээ, төсвөөс санхүүжих орлогууд тус тус тасарсан үзүүлэлттэй гарчээ.

Сургалтын төлбөрийн орлого тасарсан шалтгаан нь сургалтын төрийн сангийн 2016-2017 оны намрын улирлын сургалтын төлбөрийн санхүүжилт -499.2 сая төгрөг хийгдээгүй болон эдийн засгийн хүндрэлтэй байдлаас улмаас хувиараа төлбөрөө төлдөг оюутны- 610.4 сая төгрөгийг төлбөрийг хойшлуулсантай холбоотой юм.

Түр сургалтын орлогын хувьд Косэн Технологийн дээд сургууль, ШУТАС-иудын тайлангийн хугацаанд үүссэн сургалтын төлбөрийн авлага нь 294.6 сая төгрөг сургалтын төлбөрөө цаг хугацаанд нь аваагүйгээс орлого тасрах шалтгаан болсон байна.

Сургуулиудын төсвийн орлогыг гүйцэтгэлтэй нь харьцуулан харуулбал:



Тайлант онд ҮТС, ЭХС-иуд орлогын төлөвлөгөөг биелүүлж, БАС, ГУУС, МехТС, МХТС, ХШУС-иуд орлогын биелэлт 90-ээс дээш хувьтай, ДАТС, ШУТАС, Косэн ТДС-иудын хувьд 67-68 хувьтай байна.

## ГУРАВ. ЗАРДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Тайлант онд төсвийн зардлын гүйцэтгэл 44,355.3 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 15,631.4 сая төгрөгөөр дутуу, 73.9%-ийн гүйцэтгэлтэй гарч урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 3.8 хувь буюу 1,760.8 сая төгрөгөөр буурчээ. Тайлант онд улс орны эдийн засаг хямралтай холбоотойгоор төлөвлөсөн, хөрөнгийн эх үүсвэр нь шийдэгдсэн, холбогдох үндэслэл, тооцоо судалгаа нь боловсруулагдсан бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг эхлүүлэх шаардлагатай байсан ч Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн 38 тоот тогтоолын дагуу хөрөнгө оруулалтын ажлуудыг зогсоож, худалдан авахаар төлөвлөсөн сургалтын тоног төхөөрөмжүүдийн худалдан авалт хийгээгүйгээс зардлын гүйцэтгэл дутуу гарсан. Нийт зардлын 87.3 хувийг сургалтын үйл ажиллагааны зардалд, 5.5 хувийг төсөл, гэрээт ажлын зардалд, 1.3 хувийг оюутны байрны зардалд, 3.0 хувийг МСҮТөв, ахлах сургуульд, 0.9 хувийг түр сургалт, 2.1 хувийг үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд тус тус зарцуулсан байна.

### 2016 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он		Урьд оноос		Төсвөөс	
			Төсөв	Гүйцэтгэл	Харьцангуй	Абсолют	Харьцангуй	Абсолют
I. Сургалттай холбоотой шууд зардал	32,552.6	34,013.9	47,334.4	32,915.6	96.8	1,098.3	69.5	14,418.8
II. Шууд бус зардал	14,803.6	11,350.7	11,344.2	10,963.1	96.6	387.6	96.6	381.1
III. Оюутны үйлчилгээний зардал	885.4	744.0	1,053.1	457.6	61.5	286.4	43.5	595.5
IV. Инноваци болон WI FI, ANDRIOD IOS-д APPLICATION холбогдсон зардал		7.5	255.0	19.0	253.3	-11.5	7.5	236.0
<b>ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>48,241.7</b>	<b>46,116.1</b>	<b>59,986.7</b>	<b>44,355.3</b>	<b>96.2</b>	<b>1,760.8</b>	<b>73.9</b>	<b>15,631.4</b>

Бүтцээр урьд оны гүйцэтгэлтэй харьцуулан авч үзвэл:

- Сургалттай холбоотой шууд зардал 1,098.3 сая төгрөгөөр
- Шууд бус зардал 387.6 сая төгрөгөөр
- Оюутны үйлчилгээний зардал 286.4 сая төгрөгөөр буурч
- Инноваци болон WI FI, ANDRIOD IOS-д зориулсан APPLICATION хэрэгжүүлэхтэй холбогдсон зардал 11.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарчээ.


Батлагдсан төсөвтэй харьцуулбал сургалттай холбоотой шууд зардал 14,418.8 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарч үүний дотор:

- Хөрөнгө оруулалтын зардал 8.7 тэрбум төгрөгөөр (үүнд хичээлийн 8-р байрны 5.6 тэрбум төгрөг, БАС-ийн лабораторийн барилгын 1.5 тэрбум төгрөг, лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах зардал 749.9 сая төгрөг, сургалтын эд хогшил худалдан авах зардал 150.0 сая төгрөгийг худалдан авалт хийгдээгүйтэй холбоотой),
- Цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал – 3.3 тэрбум төгрөг,
- Хичээл практикийн зардал 1.4 тэрбум төгрөг,
- Ном хэвлэлийн зардал 358.5 сая төгрөг,
- Эрдэм шинжилгээний зардал -159.0 сая төгрөг,
- Багшийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх зардлууд 451.0 сая төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Шууд бус зардал 381.1 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан хэдий ч харуул хамгаалалтын зардал 67.4 сая төгрөгөөр (харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь өөрчлөгдсөн гэрээ шинэчлэгдсэн хийгдсэнээс), бусад зардал 765.6 сая төгрөг (үүнд голчлон ҮТС цайны газрын зардлыг төлөвлөгөөгүйгээс -427.0 сая төгрөг, Эрдэмнэт төвийн зардал 440.0 сая төгрөг орж нэгтгэгдсэнээс)-өөр хэтэрсэн дүнтэй байна.

Оюутны үйлчилгээний зардал 595.5 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан нь МехТС-ийн МСҮТ-ийн суралцагчдад олгодог тэтгэлийг сургуулиар дамжуулахгүйгээр суралцагчдад шууд олгодог болсонтой холбоотой юм. Инноваци болон WI FI, ANDRIOD IOS-д зориулсан APPLICATION хэрэгжүүлэхтэй холбогдсон зардал төсөвлөсөн хэмжээнээс 236.0 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан нь төлөвлөсөн ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сургууль тус бүрээр харуулбал:



Бүрэлдэхүүн сургуулиудын хувьд тэвчиж болох зардлуудыг хойшлуулж, зардлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлснээр зардлаа нийт дүнгээр нь хэтрүүлсэн сургууль, нэгж байхгүй.

## ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

Оюутны байгууллагын үйл ажиллагааг дэмжих, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг урамшуулах, урлаг, спортын наадмыг уламжлал болгон зохион байгуулах, оюутанд үзүүлэх үйлчилгээг өргөтгөх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрөөхөд зэрэг ажлуудад тайлант онд 457.6 сая төгрөг зарцуулсан нь урьд оны гүйцэтгэлээс 62.6 хувь буюу 286.4 сая төгрөгөөр, төсөвлөснөөс 2.3 дахин буюу 595.6 сая төгрөгөөр тус тус буурчээ. МехТС-ийн МСҮТөвийн суралцагч оюутны тэтгэлэг нь сургуулиар нь дамжихгүй шууд олгогдох болсноор оюутны тэтгэлэг хөнгөлөлтийн зардал буурч гарчээ. 2015-2016 оны хичээлийн жилд 2900 оюутан, 2016-2017 оны хичээлийн жилд 3900 оюутан элссэн нь хөдөө орон нутгаас элсэгчдийн тоо цөөн байгаатай холбоотойгоор оюутны унааны зардлын гүйцэтгэл буурахад нөлөөлжээ.

### ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он		Урьд оноос		Төсвөөс	
			төсөв	гүйцэтгэл	Харьцан гуй	Абсолют	Харьцан гуй	Абсолют
Оюутны эрдэм шинжилгээний зардал	73.5	80.8	136.4	101.9	79.3	(21.1)	133.9	34.5
Оюутны спорт, урлагийн арга хэмжээний зардал	109.8	78.8	119.9	99.9	78.9	(21.1)	120.0	20.0
Магистр, доктор оюутны арга хэмжээний зардал	4.5	34.5	37.1	28.4	121.5	6.1	130.6	8.7
Оюутны тэтгэлэг, хөнгөлөлт	501.8	347.7	550.6	94.1	369.5	253.6	585.1	456.5
Оюутны унааны зардал	195.9	202.2	209.2	133.3	151.7	68.9	156.9	75.9
<b>Оюутны үйлчилгээний зардлын дүн</b>	<b>885.5</b>	<b>744.0</b>	<b>1,053.2</b>	<b>457.6</b>	<b>162.6</b>	<b>286.4</b>	<b>230.2</b>	<b>595.6</b>

Оюутны үйлчилгээний зардлыг бүтэц талаас оюутны эрдэм шинжилгээний ажлын зардал 34.5 сая төгрөгөөр, оюутны спорт урлагийн арга хэмжээ 20.0 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан байна. Оюутны үйлчилгээний зардлын 60 хувийг оюутны эрдэм шинжилгээний зардалд, 40 хувийг оюутны урлаг спортын арга хэмжээнд зарцуулах нормтойгоос тайлант онд оюутны эрдэм шинжилгээний зардалд 50.7 хувийг, оюутны спорт урлагийн арга хэмжээнд 49.3 хувийг зарцуулсан байна. Иймд оюутны судалгаа, шинжилгээний ажлын чанарыг сайжруулах, оюутанд бүтээлч ажил хийхэд дэмжлэг үзүүлэх замаар оюутны мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх чиглэл рүү анхааран ажиллах шаардлагатай байна.

Үзүүлэлт	Нэг оюутанд ноогдох зардал /төгрөг/			
	2013 он	2014 он	2015 он	2016 он
Оюутны үйлчилгээний зардал	9,539.0	8,849.0	8,236.0	11,685.0
Эрдэм шинжилгээний	3,263.0	3,547.0	4,168.0	5900.0
Спорт урлагийн	6,276.0	5,302.0	4,068.0	5785.0

Тоёото-ШУТИС сан -6, Мицубиши -4, Зориг сан-36, Оюу Толгой ХК-44, Дэлхийн зөн-33, Ерөнхийлөгчийн нэрэмжит-1, Эрдэнэс таван толгой -3, бусад сан ААНБ, ТББ-аас нийт 167 оюутан 209.5 сая төгрөгийн тэтгэлэг болон сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн байна. Сургуулиас 577 оюутанд 94.1 сая төгрөг, урлаг спорт уран сайхнаар 192 оюутан 26.7 сая төгрөг, ОЗ-н урамшуулал 54 оюутан 11.8 сая төгрөг, дотуур байрны ОЗ-н урамшуулал 17 оюутан 4,6 сая төгрөг, захирлын нэрэмжит урамшуулал 150 оюутанд 14.2 сая төгрөгийг тус тус олгожээ.

### 3.4 ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ШИНЖИЛГЭЭ


ШУТИС-ийн дүнгээр цалин, НДШ-ийн зардал төсвийн нийт зардлын 69.1 хувийг, (өнгөрсөн онд нийт зардалд 66.7 хувь байсан) нийт орлогын 65.3 хувь, сургалтын төлбөрийн орлогын 82.1 хувийг эзэлж, зардлын гүйцэтгэл нь 30.7 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь урьд оны мөн үетэй харьцуулбал 68.1 сая төгрөгөөр буурсан дүнтэй гарчээ.

Цалингийн зардлыг батлагдсан төсөвтэй харьцуулж үзвэл 89.5 хувийн биелэлттэй буюу 3.58 тэрбум төгрөгийн хэмнэлттэй байна. Бүтцээр нь авч үзвэл сургалттай холбоотой шууд зардал дахь цалин, ндш, нэмэгдэл 87.9 хувийн биелэлттэй, 3.3 тэрбум төгрөгөөр, бусад ажилтны цалин, нэмэгдэл, НДШ 96.2 хувийн биелэлттэй 260.8 сая төгрөгөөр хэмнэгджээ.

#### ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)


Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он		Урьд оноос		Төсвөөс	
			Төлөвлө-гөө	Гүйцэт-гэл	Харьцангуй	Аб-солют	Харьцангуй	Аб-солют
<b>Цалин нэмэгдэл, шимтгэл.хамт</b>	<b>22,558.8</b>	<b>24,131.9</b>	<b>27,340.1</b>	<b>24,020.3</b>	<b>99.5</b>	<b>111.6</b>	<b>87.9</b>	<b>3,319.8</b>
Багшийн цалин	14,153.2	15,405.7	17,634.3	14,738.5	95.7	667.2	83.6	2,895.8
Сур.мастер, инж СА-ны ажилтны цалин	1,423.1	1,454.6	1,641.9	1,491.1	102.5	(36.5)	90.8	150.7
Хичээлийн туслах ажилтны	394.6	409.6	428.2	404.3	98.7	5.3	94.4	23.9
ЭША	359.4	340.8	429.9	599.6	175.9	(258.8)	139.5	(169.7)
Илүү цагийн хөлс	2,097.4	2,190.0	2,404.3	2,207.6	100.8	(17.6)	91.8	196.7
Цагийн багшийн хөлс	493.4	492.6	701.6	827.7	168.0	(335.1)	118.0	(126.1)
Нэмэгдэл	1,330.9	1,448.0	1,402.6	1,401.6	96.8	46.4	99.9	0.9
НДШ	2,306.8	2,390.6	2,697.4	2,349.9	98.3	40.7	87.1	347.5
<b>Цалин нэмэгдэл, шимтгэл.хамт</b>	<b>6,234.8</b>	<b>6,612.4</b>	<b>6,916.7</b>	<b>6,655.9</b>	<b>100.7</b>	<b>(43.5)</b>	<b>96.2</b>	<b>260.8</b>
Удирдах ажилтны цалин	122.9	137.2	146.3	109.0	79.5	28.2	74.5	37.2
Бусад ажилтны цалин	5,009.7	5,319.6	5,542.2	5,366.8	100.9	(47.2)	96.8	175.4
Нэмэгдэл, илүү цаг	493.1	503.5	542.8	517.3	102.7	(13.8)	95.3	25.5
НДШ	609.1	652.1	685.5	662.8	101.6	(10.7)	96.7	22.7
<b>Нийт цалингийн зардлын дүн</b>	<b>28,793.6</b>	<b>30,744.3</b>	<b>34,256.8</b>	<b>30,676.2</b>	<b>99.8</b>	<b>68.1</b>	<b>89.5</b>	<b>3,580.6</b>

Цалингийн сангийн бүтцийг авч үзвэл:



Ажиллагчдын дундаж цалингийн судалгаа (мян төг)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	3 жилийн дундаж	Харьцангуй өсөлт	
					2016/2015	2016/3 дундаж
Багшийн дундаж цалин	1,406.2	1,596.7	1,663.5	1,555.5	104.2	106.9
Захиргааны ажилтны дундаж цалин	1,291.8	1,404.4	1,496.6	1,397.6	106.6	107.1
Гүйцэтгэх ажилтны дундаж цалин	653.4	704.4	745.8	701.2	105.9	106.4
<b>Дундаж цалин</b>	<b>1,117.1</b>	<b>1,235.2</b>	<b>1,302.0</b>	<b>1,218.1</b>	<b>105.4</b>	<b>106.9</b>



ШУТИС-ийн хэмжээнд цалингийн өсөлт нь илүү цаг, нэмэгдлийн өөрчлөлтөөс хамаарч багшийн дундаж цалин 3 жилд дунджаар 6.9 хувиар өсөж байна

## ДӨРӨВ. НЭГ ОЮУТАНД НОГДОЖ БУЙ ЗАРДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Тайлант оны нэг оюутанд ноогдож буй дундаж зардлыг сургалтын зардлын нийт дүнгээс төсвөөс санхүүжигдсэн зардлууд, сургууль хоорондын тооцоогоор авсан мөнгийг хасч, бакалавр оюутны дундаж тоонд харьцуулан гаргахад ШУТИС-ийн хэмжээнд 1,545.0 мянган төгрөг байна.

Сургуулийн нэр	БАС	БУХС	ГУУС	ДаТС	МехТС	МХТС	ҮТС	ХШУС	ЭХС	ГХИ	ШУТИС-ийн дундаж
Нэг оюутанд ногдох зардал (мян төг)	1,783	2,194	1,964	2,006	2,227	1,972	2,136	2,157	1,947	2,333	<b>2,072</b>

ШУТИС-ийн нэг оюутанд ногдож буй зардал нь Удирдах зөвлөлөөс тогтоосон 1 кредитийн үнэлгээний дундажаас тооцсон 1 оюутны жилийн дундаж төлбөр 1,780.2 мянган төгрөг байгаагаас 292.0 мянган төгрөгөөр илүү байна. 2016 онд төсөвлөсөн зардлуудыг нилээн их хэмжээнд хэмнэсэн байдалтай ажилласан. Дийлэнх бүрэлдэхүүний сургуулиудын хувьд ШУТИС-ийн батлагдсан дундажаас дээгүүр байгаа нь жил ирэх бүр орлогын өсөлт зардлын өсөлтөө гүйцэхгүйгээс, цалин НДШ-ийн зардал өсөх, сургалтын материаллаг орчин, лабораторийн шинэчлэл зэрэг зардлыг шилжих үлдэгдлээс санхүүжүүлж байгааг илтгэж байна. Иймд сургалтын төлбөрийг 1 оюутанд ногдох зардлын хэмжээнд батлуулах шаардлагатай.

Хичээлийн жил	Инфляци*	1 кредит. үнэлгээ (төг)	харьцангуй өсөлт (хувь)	Абсолют цэвэр өсөлт (төг)	хэлхээ өсөлтийн коэф	цэвэр өсөлтийн 1%-д ногдох төлбөр (төг)	сургалтын төлбөрийн орлого	сургалттай холбоотой шууд зардал
2006-2007	5.10	15,547.0					7882.1	4386.9
2007-2008	9.00	17,283.0	10.04	1,736.0	1.11	172.83	9378	8671.7
2008-2009	25.10	23,675.0	27.00	6,392.0	1.37	236.75	11619	11306.1
2009-2010	6.30	27,516.0	13.96	3,841.0	1.16	275.16	16062.9	14607.2
2010-2011	10.15	31,093.0	11.50	3,577.0	1.13	310.93	20917.9	16149.3
2011-2012	9.50	34,016.0	8.59	2,923.0	1.09	340.16	25759.1	21762.4
2012-2013	14.98	38,009.0	10.51	3,993.0	1.12	380.09	28556.9	27433.1
2013-2014	8.60	43,225.0	12.07	5,216.0	1.14	432.25	32952.5	31773.7
2014-2015	13.00	49,450.0	12.59	6,225.0	1.14	494.50	34994.9	32552.6
2015-2016	5.77	59,340.0	16.67	9,890.0	1.20	593.40	36859.7	34013.9
2016-2017	1.60	59,340.0	-	-			34375	32915.6
<b>дундаж</b>		<b>36,226.7</b>	<b>12.29</b>	<b>4,379.3</b>	<b>1.16</b>	<b>359.6</b>	<b>23578.0</b>	<b>21415.7</b>

\*www.dataworldbank.org сайтаас авав.

## ТАВ. ОЮУТНЫ БАЙРНЫ ОРЛОГО, ЗАРДЛЫН ШИНЖИЛГЭЭ

ШУТИС нь оюутны 6 байртай бөгөөд БАС-ийн оюутны байр нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2010 оны 4 сарын 15-ны өдрийн № 07-354/96 тоот улсын байцаагчийн актаар үйл ажиллагаа явуулж ашиглахыг зогсоосон. Тайлант онд ШУТИС-ийн 5 оюутны байранд 1227 оюутан, 93 багш ажилтан амьдарч, байр ашиглалт 71.7 хувьтай, оюутны байрны орлого 1077.2 сая төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөний биелэлт 60%-тай байна. Орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан нь МХТС оюутны байрны их засварт улсын төсвөөс авахаар 550.0 сая төгрөгийг төсөвлөсөн, БУХС-ийн оюутны байрны тогтмол зардлын санхүүжилт хийгдээгүйтэй холбоотойгоор орлогын төлөвлөгөө тасарчээ.



## ОЮУТНЫ БАЙРНЫ ОРЛОГО, ЗАРЛАГА (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он		Өөрчлөлт/Төсөв	
			төсөв	гүйцэтгэл	Биет хэмжээ	Хувиар
Оршин суугч оюутан, багш, ажилчид	775.6	689.2	881.1	809.9	(71.2)	91.9
Улсын төсөв	297.2	347.8	664.4	116.7	(547.7)	17.6
Төвлөрүүлсэн				100		
Нийт орлого	1,072.80	1,037.00	1545.5	1026.6	(518.9)	66.4
Нийт зардал	838.6	786.2	1619.0	996.4	(622.6)	61.5
<b>Үр дүн</b>	<b>234.2</b>	<b>250.8</b>	<b>(73.5)</b>	<b>30.20</b>		

Тайлант онд хөрөнгө оруулалтын чиглэлээр МХТС оюутны байрныхаа 1-р давхрын засварт 75.5 сая төгрөг, гадна фасад 63.2 сая төгрөг, цахилгаан хангамжийн засварт 60.0 сая төгрөг нийт 198.7 сая төгрөгийг зарцуулсны 100.0 сая төгрөгийг Ректорын 2016 оны 10 сарын 25-ны А154 тоот тушаалаар БАС, ЭХС, ХШУС, ГУУС-иудаас төвлөрүүлэн зарцуулсан.

Үзүүлэлт	БУХС	МехТС	МХТС	ҮТС	ДТС	ЗАА
Орлого	221.5	171.1	219.3	218.1	113.7	25.8
Зарлага	239.9	124.1	318.9	191.9	95.7	25.8
<b>Үр дүн</b>	<b>-18.4</b>	<b>47.0</b>	<b>-99.7</b>	<b>26.2</b>	<b>17.7</b>	<b>0.0</b>
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>114.6</b>	<b>31.6</b>	<b>39.2</b>	<b>79.1</b>	<b>18.1</b>	<b>-</b>

БУХС-ийн оюутны байрны орлого зардлын зөрүү нь сөрөг үр дүнтэй байгаа нь улсын төсвөөс санхүүжүүлэх тогтмол зардлын санхүүжилтийн авлагатай холбоотой юм.

МХТС-ийн оюутны байрны орлого зардлын зөрүү нь сөрөг үр дүнтэй гарсан нь урьдчилж орсон орлогын 39.2 сая төгрөгийг зарцуулсан, оюутны байрны уур ус, гэрэл цахилгааны, түлш халаалтын зардлын авлагатай учраас сөрөг үр дүнтэй гарсан байна.

Нийт зардлын 33.7 хувийг цалин, шимтгэлийн зардал, 35.0 хувийг тогтмол зардал, 20.2 хувийг хөрөнгө оруулалт, урсгал засварын зардал 7.3 хувийг, 3.8 хувийг бусад зардал эзэлж байна.

### ЗУРГАА. ТӨВЛӨРСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ ОРЛОГО, ЗАРДАЛ

Тайлант оны орлогыг үндсэн үйл ажиллагааны, туслах үйл ажиллагааны, төсвөөс санхүүжих гэж авч үзлээ. Орлогын дүнг Үр дүнгийн /СТ-2А/ тайлангаас авч орлогыг тооцлоо. Захиргааны нийт орлого тайлант онд 3,6 тэрбумд хүрч өмнөх оноос 3%, батлагдсан төсвөөс 16%-иар тус тус буурсан байна.

### ТӨВЛӨРСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)

Орлогын төрөл	2014 он	2015 он	2016 он		Төсвөөс өссөн, буурсан		Урд оноос	
			Төсөв	Гүйцэтгэл	Аб солют	Харь цангуй	Аб солют	Харь цангуй
<b>1. Үндсэн үйл/аж</b>	2,665.9	3,379.7	3,518.9	3,129.3	(389.6)	88.9	250.4	92.6
Төвлөрүүлсэн	1,833.0	3,373.0	3,018.9	3,129.3	110.4	103.7	243.7	92.8
Шилжих үлдэгдэл	751.0	-	500.0	-	(500.0)	-	-	-
Сургалтын төлбөр	81.9	6.7	-	-	-	-	6.7	-
<b>2. Туслах үйл/аж</b>	428.7	312.8	648.6	295.5	(353.1)	45.6	17.3	94.5
Түрээсийн орлого	51.7	30.1	33.5	19.2	(14.3)	57.4	10.9	63.9
Байрны орлого	54.4	29.1	72.8	37.0	(35.8)	50.8	(7.9)	127.1

Түр сургалт орлого	238.8	163.0	130.0	113.7	(16.3)	87.5	49.3	69.7
Бусад	83.8	90.6	117.0	125.5	8.5	107.3	(35.0)	138.6
PR төсөв	-	-	295.3	-	(295.3)	-	-	
<b>3. Төсвөөс санхүүжих</b>	187.9	82.8	224.5	262.8	38.3	117.1	(180.0)	317.4
<b>ДҮН</b>	<b>3,282.4</b>	<b>3,775.3</b>	<b>4,392.0</b>	<b>3,687.6</b>	<b>(704.5)</b>	<b>84.0</b>	<b>87.7</b>	<b>97.7</b>

Нийт орлогын дүнд эзлэх хувь:

- Үндсэн үйл ажиллагааны орлого 84.8%
- Туслах үйл ажиллагааны орлого 8.0 %
- Төсвөөс санхүүжих орлого 7.2 %

## ДОЛОО. САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Санхүүгийн гол үзүүлэлтийг үндэслэн сүүлийн 3 жилээр санхүүгийн харьцааны шинжилгээг хийлээ.

ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ	2014	2015	2016
<b>1. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ</b>			
1.1 Бие даалтын коэффициент	0.88	0.91	0.91
<b>2. Төлбөрийн чадварын шинжилгээ</b>			
2.1 Эргэлтийн харьцаа	4.0	5.0	5.12
2.2 Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	44.09	44.72	47.78
2.3 Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин	30.00	35.86	38.54
<b>3. Эргэцийн шинжилгээ</b>			
3.1 Нийт хөрөнгийн эргэц	0.64	0.66	0.57
3.2 Эргэлтийн хөрөнгийн эргэц /удаа/	1.34	1.38	1.10
3.3 Эргэлтийн хөрөнгийн эргэц /хоног/	268	261	327
3.4 Авлагын эргэц /удаа/	7.39	6.50	5.34
3.5 Авлагын эргэц /өдөр/	49	55	67
3.6 Бараа материалын эргэц /удаа/	46.02	21.79	17.26
3.7 Бараа материалын эргэц /өдөр/	8	17	21
<b>4. Ашигт ажиллагаа</b>			
4.1 Нэг төгрөгийн орлого олоход гарах зардал	0.89	0.85	0.95

- ШУТИС-ийн нийт хөрөнгийн 91.0 хувь нь өөрийн хөрөнгөөс, 9 хувь нь гадны эх үүсвэрээс бүрдэж байна. Гадны эх үүсвэрээс хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулах бүрэн чадвартайг харуулж байна.
- Төлбөрийн чадварын хувьд богино хугацаат өр төлбөрийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлагаараа 5.0 удаа барагдуулах боломжтой байна.
- Нийт хөрөнгийн 47.8 хувийг эргэлтийн хөрөнгө хэлбэрээр ашиглаж байна. Үүнд мөнгө, авлага, бараа материал хамаарна.
- Нийт хөрөнгийн 38.5 хувийг цэвэр эргэлтийн хөрөнгө байдлаар ашиглаж байна.
- Нийт хөрөнгийн эргэцийн шинжилгээнээс харахад 2015 оны хувьд нэг төгрөгийн хөрөнгө ашиглаад 0.66 төгрөгийн орлоготой ажилласан бол 2016 онд 0.57 төгрөгийн орлого олсон буюу өмнөх оноос 9 мөнгөөр буусан.
- Эргэлтийн хөрөнгө нь жилд 1.1 удаа буюу 327 хоногт нэг эргэж, урьд оны үзүүлэлттэй харьцуулбал эргэлтийн хөрөнгийн эргэц удааширсан байна.
- Авлага жилд 5.3 удаа буюу 67 өдөрт нэг эргэж урд оноос авлагын эргэц удааширсан нь авлагын хэмжээ өссөнтэй холбоотой.
- Бараа материал 17.3 удаа буюу 21 өдөрт нэг эргэж өмнөх оноос эргэц удааширсан нь бараа материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой.
- 2015 онд 1 төгрөгийн орлого олохын тулд 0.85 төгрөгийн зардалтай ажиллаж байсан бол тайлант онд 0.95 төгрөгийн зардал гаргажээ. Хандив тусламжаар мөнгөн бус биет хөрөнгөөр авсан орлогыг хасч тооцоход 1 төгрөгийн орлогод ноогдох зардал 0.97 төгрөг болсон.

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

2016 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институт, ахлах сургууль, дээд сургууль, захиргаа, эрдэм шинжилгээний алба, хүрээлэн, хэвлэлийн газар, Эрдэмнэт сүлжээний төв зэрэг нийт 21 нэгжийн хүрээнд нэгдсэн тайлан баланс гаргалаа. Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн шинжилгээний үр дүнг бүрэлдэхүүн нэгж тус бүр захирлын зөвлөлийн хурлаар, 3 сарын 16-20 өдрүүдэд ШУТИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцэн санал, дүгнэлт, зөвлөмжүүдийг өгсөн. Мөн Ректоратын 2017 оны 3 сарын 21-ний өдрийн хурлаар ШУТИС-ийн нэгдсэн тайлан, бүрэлдэхүүн сургуулиуд, нэгжүүдийн санхүүгийн шинжилгээний үр дүнг хэлэлцсэн.

Балансын бүтцийн шинжилгээ: Тайланд онд нийт хөрөнгийн хэмжээ 86.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 3.3 тэрбум төгрөгөөр буюу 4 хувиар нэмэгдсэн. Энэхүү хөрөнгө нэмэгдэхэд мөнгөн хөрөнгө 3.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь эерэгээр нөлөөлжээ. Харин авлагын хэмжээ 656.4 сая төгрөгөөр, өр төлбөр 623.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сөргөөр нөлөөлсөн. Шинжилгээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийг хооронд нь харьцуулан дүгнэлт, санал, зөвлөмжийг өгч ажиллалаа. Мөнгөн хөрөнгө болон цэвэр шилжих үлдэгдлийн үзүүлэлтээр 100 сая төгрөгнөөс дээгүүр өсгөсөн БАС, МХТС, ҮТС, ЭХС-д хангалттай, харин 100 сая төгрөгнөөс доогуур бууруулсан БУХС, ГУУС, ШУТАС зэрэг нэгжүүд байна. Авлагын үзүүлэлтээр 100 сая төгрөгнөөс дээгүүр бууруулсан ҮТС, ЭША хангалттай, харин 100 сая төгрөгнөөс дээгүүр өсгөсөн БУХС, ГУУС, ШУТАС, ОУДБСТ байна. Өр төлбөрийн үзүүлэлтэд богино хугацаат өр төлбөрөөс сургалтын төлбөрийн урьдчилж олсон орлогыг хассан үзүүлэлтээр харьцуулсан. Уг үзүүлэлтээр 50 сая төгрөгнөөс дээгүүр бууруулсан ҮТС, Захиргаа хангалттай, харин 10 сая төгрөгнөөс дээгүүр өсгөсөн ГХИ, ОМССХ байгаа юм. Шинжилгээний үр дүнд тулгуурлан цаашид бүрэлдэхүүн нэгжүүдээс СТСангийн суутганы авлагыг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, бараа материалын дансны үлдэгдэл жил ирэх бүр нэмэгдэж байгаа тул хасуулах, технологи сангийн төслийн авлагуудыг сургууль хоорондын авлагаар нэмж бүртгүүлэх зэрэг саналуудыг гаргасан.

Орлогын шинжилгээ: Тайланд онд 2016 онд 46.9 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь төсөвтэйгөө харьцуулахад 100 хувийн гүйцэтгэлтэй боловч өмнөх онтой харьцуулахад 5.6 тэрбум төгрөгөөр буурчээ. Төсөв болон гүйцэтгэлийн хувьд орлогын төрөл тус бүрээр харьцуулахад төсвөөс санхүүжүүлэх дүн 2.1 тэрбум төгрөгөөр, сургалтын төлбөрийн орлого 683.0 сая төгрөгөөр, ЭШ-ний орлого 163.0 сая төгрөгөөр тасарчээ. Харин хүүгийн орлого, хандивын орлого, үйлдвэрлэл үйлчилгээний орлогууд болох бусад орлогын үзүүлэлт 3.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь эерэгээр нөлөөлжээ. Орлогын төсөв болон гүйцэтгэлээр ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийг харьцуулахад ҮТС, ЭХС 20 хувиар дээгүүр орлогоо нэмэгдүүлсэн хангалттай, ДаТС, ГХИ, ШУТАС, Косэн нэгжүүд 20 хувиар доогуур орлогоо бууруулсан үзүүлэлт гарсан. Сургалтын төлбөрийн орлогын үзүүлэлтээр ЭХС, БАС, ҮТС, МехТС 200.0 сая төгрөгнөөс дээш орлогоо нэмэгдүүлсэн хангалттай, ГУУС, ДаТС 1 тэрбум төгрөгнөөс дээш орлогоо тасалдуулсан байна. Харин ЭШ-ний орлогын үзүүлэлтээр ГУУС, ҮТС, ЭХС 200.0 сая төгрөгнөөс дээш орлогоо нэмэгдүүлсэн хангалттай, БАС, БУХС 60.0 сая төгрөгнөөс дээш орлогоо биелээгүй байна. Төсвөөс санхүүжүүлэх орлогын үзүүлэлтээр тогтмол зардлын санхүүжилт 739.5 сая, МСҮТ-ийн санхүүжилт 630.0 сая, СТС-ийн сургалтын төлбөрийн санхүүжилт 499.0 сая төгрөгөөр тасарчээ. ШУТИС-ийн орлогын сүүлийн 10 жилийн өсөлт 3.7 хувь, зарлагын өсөлт 4.3 хувь байгаа нь санхүүгийн нөөцийг бүрдүүлэх тал дээр цаашид анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна. Тухайлбал сургалтын төлбөрийн орлогоос бусад орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, орлогын уян хатан бодлого авч хэрэгжүүлэх саналтай байна.

Зардлын шинжилгээ: Тайланд онд 44.3 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 15.6 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарч өмнөх онтой харьцуулахад 1.7 тэрбум төгрөгөөр буурчээ. Төсөв болон гүйцэтгэлийн хувьд зардлын төрөл тус бүрээр харьцуулахад сургалттай холбоотой шууд зардал 14.4 тэрбум төгрөгөөр тасарчээ. Үүнд хөрөнгө оруулалтын зардал болох хичээлийн 8-р байр 5.6 тэрбум, БАС-ийн лабораторийн байр 1.5 тэрбум, лабораторийн тоног төхөөрөмж 749.0 сая, цалингийн зардал 3.3 тэрбум, хичээл практикийн зардал 1.4 тэрбум, ном хэвлэлийн зардал 358.0 сая, ЭШ-ний зардал 159.0 сая төгрөгөөр тасарсан нь нөлөөлсөн. Зардлын үзүүлэлт тус бүрээр харьцуулахад сургалттай холбоотой шууд зардал болох тогтмол зардал 93.6 сая төгрөгөөр, шууд бус зардал болох харуул хамгаалалтын зардал 67.4 сая төгрөгөөр, бусад зардал 765.6 сая төгрөгөөр төсвөөс хэтэрчээ. Зарлагын төсөв болон гүйцэтгэлээр ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийг харьцуулахад ҮТС, ЭХС 90 гаруй хувийн гүйцэтгэлтэй хангалттай, БАС, ДаТС, ЕНИ, ОМССХ, Косэн нэгжүүд 60 хувиас доогуур гүйцэтгэлтэй гарчээ. Багшийн мэргэжил дээшлүүлэх зардалд давхардсан тоогоор 974 багшийг

магистр, докторын сургалтын төлбөр, богино хугацаат сургалтын төлбөр, гадаад хурал, семинарын үйл ажиллагаанд 611 сая төгрөг зарцуулсан. Тус онд цалингийн зардал 3.3 тэрбум төгрөгөөр буурч гарсан нь өмнөх оноос үндсэн орон тооны 20 багш хасагдаж 1037 профессор, багш нар ажиллаж, багш нарын 14 хувь нь гадаадад суралцах, жирэмсний амралт, өвчтэй, чөлөөтэй байсантай холбоотой. Хамтын гэрээний дагуу 2016 оны 9 сард цалинг 3-5 хувиар нэмэгдүүлснээр тус онд 201.1 сая төгрөгийн нэмэгдэл олгосон. Мөн ШУТИС-ийн хувьд нийт орлогын 65 хувийг, сургалтын төлбөрийн орлогын 82.1 хувийг цалингийн зардал эзлэж байна. Үүнээс бүрэлдэхүүн нэгжээс нийт орлогод эзлэх цалингийн зардлын хувь хэмжээний үзүүлэлтээр ДаТС-д 88.6 хувь, ГХИ-д 92.9 хувь, ЕНИ-д 73.3 хувьтай хамгийн өндөр гарсан. Энэ нь тус нэгжүүдийн балансын, орлого, зарлагын шинжилгээний үр дүнгийн үзүүлэлт болох тайлант үеийн үр дүн бага гарахад нөлөөлжээ. Шинжилгээний үр дүнд тулгуурлан цаашид бүрэлдэхүүн нэгжүүдээс ШУТИС-ийн ректорын 2006.12.15 ны өдрийн 314 тоот тушаалаар баталсан "ШУТИС-ийн багш нарыг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх үлгэрчилсэн түр журам"-ыг шинэчлэх, санхүүгийн албаны ажлын ачаалалыг зөв хувиарлаж цалингийн системийг өөрчлөх, үндэсний магадлан итгэмжлэлийн шинжээчдийн зардлыг журмаар зохицуулах, офсет хэвлэлийн машин шинээр худалдан авалт хийх зэрэг саналыг гаргасан.

Нэг оюутанд ноогдох зардлын шинжилгээ: 2015 онд удирдах зөвлөлөөр 1 кредитийн үнэлгээ 59.340 төгрөгөөр тогтоосон нь сүүлийн 2 жилд өөрчлөгдөөгүй. Мөн өнгөрсөн онуудад элсэгч оюутны тоо буурснаас хамаарч сургалтын төлбөрийн орлого 2016 онд 683.0 сая төгрөгөөр тасарсан байна. ШУТИС-ийн хэмжээнд нэг оюутанд ноогдох зардлын хэмжээ 2072.0 мянган төгрөг гарсан нь удирдах зөвлөлөөс тогтоосон 1780.0 мянган төгрөгөөс 292.0 мянган төгрөгөөр илүү байна.

Оюутны байрны орлого зардлын шинжилгээ: Тайланд онд ШУТИС-д үйл ажиллагаа явуулж байгаа 5 оюутны байрны орлогыг 1.5 тэрбум төгрөгөөр, зардалыг 1.6 тэрбум төгрөгөөр баталсан. Гэвч 2016 онд 1.0 тэрбум төгрөгийн орлоготой, 996.0 сая төгрөгийн зардалтай ажилласан. Өнгөрсөн онд оюутны байр гэлтгүй нийт бүрэлдэхүүн сургуулиуд нэгжүүдийн хувьд хөрөнгө оруулалтын зардал, капиталжуулалтын зардал, цалингийн зардал зэргийг бууруулж ажиллажээ. Шинжилгээний үр дүнд тулгуурлан Удирдах зөвлөлд оюутны нэг кредитийн үнэлгээг нэмэгдүүлэх саналтай байна.

Төвлөрсөн арга хэмжээний орлого, зардлын шинжилгээ: Тайланд онд бүрэлдэхүүн сургуулиудаас 3.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан. Мөн захиргааны төв номын сангийн, эрүүл мэндийн төвийн, технологи дамжуулалт инновацийн төвүүдийн үйл ажиллагаанд зарцуулсан. 2016 онд төвлөрсөн арга хэмжээнд 2.0 тэрбум төгрөг, номын сангийн зардалд 441.0 сая төгрөг, ХУБА-нд 308.0 сая төгрөг, эрүүл мэндийн төвд 70.6 сая төгрөг, бусад төвлөрөлд 129.0 сая төгрөг зарцуулагдсан. Бусад төвлөрөлд ШУТИС-ийн 55 жилийн ойн арга хэмжээ, хөндлөнгийн аудитийн үйлчилгээний зардал, дижитал тоног төхөөрөмжийн зардалд зарцуулсан.

Санхүүгийн харьцааны шинжилгээ: Тайланд онд бие даалтын коэффициент 0.91 гарч нийт хөрөнгийн 91 хувь нь өөрийн хөрөнгийн эх үүсвэртэй байна. Төлбөрийн чадварын шинжилгээний үр дүнд эргэлтийн хөрөнгө нийт хөрөнгийн 47 хувийг, цэвэр хөрөнгө нийт хөрөнгийн 38 хувийг эзлэж байгаа ба эргэлтийн хөрөнгөөр өр төлбөрөө 5 удаа нөхөх боломжтой үр дүн гарлаа. Эргэцийн шинжилгээгээр нэг төгрөгийн хөрөнгө ашиглаад 0.57 төгрөгийн орлого олж байгаа, эргэлтийн хөрөнгө 1.1 удаа буюу 327 хоногт нэг эргэж байгаа, авлага жилд 5.3 удаа буюу 67 хоногт нэг эргэж байгаа, бараа материал жилд 17.2 удаа буюу 21 хоногт нэг эргэж байгаа үр дүн гарчээ. Ашигт ажиллагааны шинжилгээгээр нэг төгрөгийн орлого олоход 0.95 төгрөгийн зардал гарч байна гэсэн үр дүн гарсан.

## ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн тайлангийн шинжилгээгээр санхүүгийн байдал ба үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэн ирээдүйн боломжоо олж харах, өртгийг бодитой тооцох, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх боломжийг тодорхойлох, удирдлагын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах үүднээс хийгддэг. Шинжилгээний хүрээнд бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн тоон үзүүлэлт, үр дүнгүүдийг харьцуулан, санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн дагуу зарцуулалт хийх, илүү үр ашигтай зарцуулах, тодорхой, бодитой, үр дүнтэй, арга замуудыг илэрхийлэх үүднээс дараах санал зөвлөмжийг гаргаж байна.

Нэгдүгээрт: Санхүүгийн тайлангийн шинжилгээг захирлын зөвлөлийн хурлаар, ШУТИС-ийн захиргааны зөвлөлөөр хурлаар, ректоратын хурлаар, удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэний дагуу:

- Санхүүгийн тайлангийн шинжилгээний үр дүн, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн нөхцөл байдалд тулгуурлан нэгж тус бүрт санхүүгийн үйл ажиллагаагаа сайжруулах, анхаарч ажиллах зөвлөмжийг хүргүүлэх
- Санхүүгийн тайлангийн шинжилгээний үр дүн, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн ажиллагчдын ажлын чиг үүргээ гүйцэтгэсэн байдал, сургалтын авлага, өр төлбөр тулган баталгаажуулалт, аудитаар илэрсэн асуудал зэргийг харгалзан үзэж хангалтгүй, зөрчил дутагдалтай ажилласан санхүүгийн ажилтануудад анхааруулах, сануулах, хариуцлага тооцох
- Санхүүгийн тайлагналийн гүйцэтгэлийн аудитын зөрчлийг арилгах чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулах

Хоёрдугаарт: Монгол улсын үндэсний аудитын газрын /САГ-2017/324/СТА-ТШЗ/ ШУТИС-ийн 2016 оны санхүүгийн аудитын тайлангийн “хязгаарлалттай санал дүгнэлт”-ийн дагуу:

- МехТС, ГУУС, Захиргаа, ЭХС нэгжүүдэд гарсан ЭШ-ний томилолтын зардлыг Сангийн сайдын 2011 оны 131 дугаар тушаалаас 9.5 сая төгрөгөөр илүү тооцон олгосон. Цаашид ЭШ-ний болон төсөл гэрээт ажлын төсвийг боловсруулахад Сангийн сайдын 131 тоот тушаалыг мөрдөх, ЭШ-ний ажлын зардлын зарцуулалтын журам боловсруулах
- ХШУС-д 40.6 сая төгрөгийн төслийн санхүүжилтийн орлогыг аккруэл сууриар бус мөнгөн сууриар бүртгэсэн нь УСНББОУС санхүүгийн тайлангийн толилуулгын “жинхэнэ хэрэгжилтийн зарчим” зөрчигдсөн. Цаашид ЭШ-ний ажлын төлөвлөлтийг тодорхой болгох, ЭШ-ний ажлын орлогын бүртгэлийн асуудлыг НББ бодлогын баримт бичигт оруулах
- ХШУС-д 23.7 сая төгрөгийн бараа материалыг өмнөх оны үр дүнд залруулах бичилт хийсэн нь НББ тухай хуулийн 20.2.3, 20.2.6 зөрчигдсөн. Цаашид бараа материалын тооллого хийх, өмч хамгаалах комиссоор тогтмол хэлэлцэх, бараа материалтай холбогдолтой журмыг сайжруулах
- БАС-д 59.1 сая төгрөгийн барилгын дээврийн засварын зардлыг авлагаар бүртгэсэн нь НББОУС 16.7-г зөрчсөн. Цаашид гэрээг цаг хугацаанд дүгнэдэг байх, авлага, өр төлбөртэй холбоотой журмыг сайжруулах
- ГХИ-д 21.3 сая төгрөгийн Русский мир байгууллагын төлбөрийг өглөгөөр бүртгэсэн нь НББ тухай хуулийн 13.7-г зөрчсөн. Цаашид ЭШ-ний ажлын орлогын бүртгэлд хамруулах, авлага, өглөгтэй холбоотой журмыг сайжруулах
- ГУУС-д 3 сая төгрөгийн кассын мөнгө орлогодож аваагүй нь НББ тухай хуулийн 13.6-г зөрчсөн. Цаашид бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд дээрх кассын орон тоог хасах, кассын тулган баталгаажуулалтыг тогтмол хийх
- БАС, БУХС, ГУУС, ДарТС, МехТС, МХТС, УТС, ХШУС, ЭХС, ГХИ зэрэг нэгжүүдэд 154.9 сая төгрөгийн сургалтын төлбөрийн бүртгэлтэй холбоотой авлага, урьдчилж орсон орлогын данс зөрж залруулга хийсэн нь зөрчилтэй. Цаашид сургалтын төлбөрийн авлага, өглөгийг “U-finance” программд шилжүүлэх, програмын боловсруулалтыг сайжруулах

Гуравдугаарт: ШУТИС-ийн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх боломжийг судлах, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах, Сургууль хоорондын тооцооны коэффициентийг судлах, санал боловсруулах, ШУТИС-ийн төлбөрт үйлчилгээний журмыг судлах, Оюутны нэг кредитийн үнэлгээг шинэчлэн боловсруулах зэрэг саналтай байна.

## ШУТИС-ийн 2021 ОН ХҮРТЭЛХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлтүүд	БАС	БУХ С	ГУУ С	ДТС	MeTC	MXT С	УТС	Х Ш УС	ЭХС	ЕНИ	ГХИ	ШУТИ С 2016*	2021 онд хүрэх түвшин
1	Багш болон оюутны тооны харьцаа	1:29	1:17		1:12	1:22	1:22		1:6	1:21	1:10	1:10	1:20	1:18
2	Нийт оюутны тоонд ахисан түвшний хөтөлбөрийн оюутны эзлэх хувь	7.4	25.0	9.8	3.2	4.0	4.3	8.5		8.3	100.0	0.1	17.1	22
3	Гадаадын орнуудаас элсэн суралцагчдын тоо	1	2	8		0	1	2	4	0		8	26	50
4	Зайн сургалтанд хамрагдсан оюутны тоо	55	0			0		0		147	98	0	300	
5	Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин, %	93.0	39.2		75.0	78.0	84.0	68.0		78.0	85.0	35.8	70.7	75
6	Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	4	12	8	2	0	9	3	0	8	0	0	46	28
	- гадаадад		7	1		0		0		1		0	9	20
	- дотоодод	4	5	7	2	0	9	3		7		0	37	8
7	Е,У хөтөлбөрийн тоо	15				1				0	35	0	51	45
8	Судалгаа ба туршилтын ажил гүйцэтгэсэн судлаачид багш нарын тоо	110	26	101	11	35	54	34	10	81	18	6	486	500
9	ОУ-ын мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлд хэвлүүлсэн ЭШ-ний бүтээлийн ишлэлийн тоо					9	7	62	90	7	2	2	179	335
10	Судалгааны ажлын үр дүн (патент, лиценз, зохиогчийн эрх, үйлдвэрлэлд нэвтэрсэн ажил)	3	4	19	3	10	14	12	11	3		4	83	505
11	ОУ, улсын санхүүжилтээр хэрэгжүүлсэн судалгааны төслийн тоо	9	4	42	1	7	9	16	9	16	2	0	115	220
12	Гарааны компанийн тоо		0			0	0	1		0		0	1	10
13	Нийт зардалд ЭШ-ний зардлын эзлэх хувь	6.0	2.8	19.0		4.1	6.6	4.6	4.7	11.3	4.1	0.0	7.0	6.0
14	Судалгаа ба инновацийн орлого, сая төгрөг	328.1	43.7			99.5	277.6	0		0	8	0	756.9	3100
15	Эрдмийн зэрэгтэй багш нарын эзлэх хувь	37.6	49	51.2	17	41	38	50.9	37.5	43	15.8	25.8	41.0	45
16	Гадаадын профессор багш, судлаачийн тоо	2	0	3	1	1	1	3	-	1	6	4	22	15
17	Мэргэжил дээшлүүлсэн профессор багшийн тоо	189	65	58	1	79	259	43	80	32	11	88	905	800
18	Судалгааны лаборатори (Нээлттэй болон олон улсад магадлагдсан)-ийн тоо		1		1	2	1	1	-	3	2	0	11	8
19	Инженерийн сургалтанд ашиглагдаж буй мэргэжлийн чиглэлийн программ хангамжийн тоо	5	0	8	36	70	31	0	17	43	8	0	218	201
20	Номын сангийн уншигчдын суудлын тоо		120		360	248	184	60	-		-	0	972	2357
21	Онлайн мэдээллийн сангийн тоо		5		2	15	9	0	1		32	0	64	24
22	Нийт орлогын өсөлт, жилийн дундаж хувь	3.4	10					12		14.6	0.9	0		15
23	Хийгдсэн хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр	441.2	165.4	248.6	140.4	213.9	401.7	69.7	27	461.7	34.1	3	2206.7	10000.0
	- Өөрийн хөрөнгөөр	441.2	165.4		69.1	74.7	311.3	33.7	27	231.9	34.1	3	1391.4	5200.0
	- Гадны хандив, тусламжаар		0	248.6	71.3	139.2	90.4	36		229.8	-	0	815.3	4800.0
24	Төр-их сургууль-бизнесийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн тоо, санхүүжилтийн дүн, сая төгрөгөөр	84.1	22.8	1.3		18.9	35			469.1		0	631.2	266/ 5339
25	Хамтын ажиллагаатай гадаадын байгууллагын тоо	24	14		6	30	10	37	19	33	11	18	202	280